

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөрөнгө оруулалт, худалдааны газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/250/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: А.Даваадорж Утас: 261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn Аудитор: Я.Марал-Эрдэнэ Утас: 261628 Цахим хаяг: maral-erdeneya@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 8 зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс биелэлт 86.5 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	22,167,910.27	2,305,960.47
33	АВЛАГА	536,904.27	473,037.51
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	68,083.27	473,037.51
33300	Татаас, санхүүжилтийн авлага	126,666.00	-
335	Бусад авлага	342,155.00	-
3351	Байгууллагаас авах авлага	342,155.00	-
34	УРЬДЧИЛГАА	20,280,843.00	939,458.96
34600	Урьдчилж гарсан зардал	4,941,843.00	939,458.96
3471	Урьдчилгаа тооцоо	15,339,000.00	-
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1,560,000.00	-
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	13,779,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	1,350,163.00	893,464.00
354	Хангамжийн материал	1,350,163.00	893,464.00
35410	Бичиг хэргийн материал	1,245,975.00	797,835.00
35420	Аж ахуйн материал	68,489.00	49,249.00
35470	Бусад хангамжийн материал	35,699.00	46,380.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	61,863,487.68	198,743,345.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	61,863,487.68	198,743,345.40
392	Биет хөрөнгө	61,863,487.68	197,505,845.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	16,470,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(6,176,250.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	59,062,253.20	116,369,753.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,029,263.38)	(33,403,735.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,850,373.44	124,649,233.44
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,019,875.58)	(20,550,656.05)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	150,000.00
393	Биет бус хөрөнгө	-	1,237,500.00
39301	Програм хангамж	-	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(412,500.00)
3	НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН	84,031,397.95	201,049,305.87
4	НИИТ ӨР ТӨЛБӨР	126,666.00	144,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	126,666.00	144,000.00
413	Өглөг	126,666.00	144,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	144,000.00
4136	Бусад өглөг	126,666.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	126,666.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	83,904,731.95	200,905,305.87
51	Засгийн газрын хувь оролцоо	83,904,731.95	200,905,305.87
512	Хуримтлагдсан үр дүн	83,904,731.95	200,905,305.87
51210	Өмнөх үеийн үр дүн	83,904,731.95	84,110,981.95
51220	Тайлант үеийн үр дүн	-	116,794,323.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	84,031,397.95	201,049,305.87

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	363,997,792.10	1,468,350,501.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,965,392.10	101,121,201.20
120	Нийтлэг татварын бус орлого	8,103,756.10	101,121,201.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,103,756.10	101,121,201.20
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,103,756.10	101,121,201.20
122	Тусламжийн орлого	2,861,636.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	2,861,636.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	353,032,400.00	1,367,229,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	353,032,400.00	1,367,229,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	353,032,400.00	1,367,229,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	280,093,060.15	1,351,556,177.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	280,093,060.15	1,351,556,177.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	252,567,440.38	893,200,349.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	94,029,916.78	476,730,633.75
210101	Үндсэн цалин	69,464,600.50	331,574,354.46
210102	Нэмэгдэл	18,135,316.28	51,243,279.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,430,000.00	58,482,000.00
210104	Урамшуулал	-	35,431,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,713,525.82	59,502,676.00
210201	Тэтгэврийн даатгал	7,965,197.54	40,461,819.86
210202	Тэтгэмжийн даатгал	937,082.06	4,760,214.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	749,665.65	2,380,107.01
210204	Ажилгүйдлийн даатгал	187,416.43	2,380,107.01
210205	Эрүүл мэндийн даатгал	1,874,164.14	9,520,428.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,716,200.00	90,623,070.00
210301	Гэрэл, цахилгаан	4,676,400.00	-
210304	Байрны түрээс	47,039,800.00	90,623,070.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,293,136.36	25,312,311.87
210401	Бичиг хэрэг	3,728,544.00	8,012,828.00
210402	Тээвэр, шатахуун	1,375,445.00	3,812,155.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,233,188.36	7,367,861.87
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,955,959.00	6,101,877.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	17,590.00
2105	Нормативт зардал	-	2,427,314.00
210502	Хоол, хүнс	-	2,427,314.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,225,644.00	10,356,299.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,612,144.00	726,499.00
210604	Урсгал засвар	3,613,500.00	9,629,800.00
2107	Томилолт, зочны зардал	18,775,588.00	34,784,242.00
210701	Гадаад албан томилолт	18,775,588.00	21,989,242.00
210702	Дотоод албан томилолт	-	9,795,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,409,220.00	163,284,959.64
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,300,000.00	145,552,724.64
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,109,220.00	17,732,235.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,404,209.42	30,178,843.48
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	1,649,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,404,209.42	28,529,843.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,525,619.77	458,355,827.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	966,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	966,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,525,619.77	457,389,327.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,525,619.77	457,389,327.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	83,904,731.95	116,794,323.92
5	НИЙТ ҮР ДҮН	83,904,731.95	116,794,323.92

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	353,159,066.00	1,367,229,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	126,666.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	126,666.00	-
120009	Бусад орлого	126,666.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	353,032,400.00	1,367,229,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	353,032,400.00	1,367,229,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	353,032,400.00	1,367,229,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	300,856,761.00	1,318,369,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	300,856,761.00	1,318,369,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	273,204,475.23	860,013,972.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	93,572,923.65	469,490,249.09
210101	Үндсэн цалин	68,992,298.55	324,395,590.56
210102	Нэмэгдэл	18,211,225.10	51,181,658.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,369,400.00	58,482,000.00
210104	Урамшуулал	-	35,431,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,238,602.22	66,974,014.90
210201	Тэтгэврийн даатгал	8,353,297.50	47,871,538.00
210202	Тэтгэмжийн даатгал	973,609.11	4,821,834.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	749,665.65	2,380,107.01
210204	Ажилгүйдлийн даатгал	196,548.19	2,380,107.01
210205	Эрүүл мэндийн даатгал	1,965,481.77	9,520,428.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,716,200.00	90,623,070.00
210301	Гэрэл, цахилгаан	4,676,400.00	-
210304	Байрны түрээс	47,039,800.00	90,623,070.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,179,367.36	24,313,470.87
210401	Бичиг хэрэг	4,841,779.00	6,951,930.00
210402	Тээвэр, шатахуун	1,617,600.00	3,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,219,988.36	7,779,861.87
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	5,981,679.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,743,231.00	13,542,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,938,631.00	1,424,700.00
210602	Тавилга	4,191,100.00	-
210604	Урсгал засвар	3,613,500.00	12,117,900.00
2107	Томилолт, зочны зардал	21,775,588.00	31,784,242.00
210701	Гадаад албан томилолт	18,775,588.00	21,989,242.00
210702	Дотоод албан томилолт	-	9,795,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,978,563.00	161,637,325.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45,860,000.00	144,582,183.60
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,118,563.00	17,055,142.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	1,649,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	1,649,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,652,285.77	458,355,827.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	966,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	966,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,652,285.77	457,389,327.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,652,285.77	457,389,327.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	52,302,305.00	48,859,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	52,302,305.00	48,859,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	52,302,305.00	48,859,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	52,302,305.00	48,859,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	52,302,305.00	48,859,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(52,302,305.00)	(48,859,500.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	83,904,731.95	83,904,731.95
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	206,250.00	206,250.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	84,110,981.95	84,110,981.95
8	Тайлант үеийн үр дүн	-	-	116,794,323.92	116,794,323.92
9	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	200,905,305.87	200,905,305.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,405,329,300.00	909,839,972.46	495,489,327.54	64.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,405,329,300.00	909,839,972.46	495,489,327.54	64.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,403,829,300.00	908,873,472.46	494,955,827.54	64.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	881,343,200.00	469,490,249.09	411,852,950.91	53.3
210101	Үндсэн цалин	539,349,800.00	324,395,590.56	214,954,209.44	60.1
210102	Нэмэгдэл	202,244,000.00	51,181,658.53	151,062,341.47	25.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	67,983,300.00	58,482,000.00	9,501,300.00	86.0
210104	Урамшуулал	71,766,100.00	35,431,000.00	36,335,100.00	49.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,168,000.00	66,974,014.90	43,193,985.10	60.8
210201	Тэтгэврийн даатгал	74,914,200.00	47,871,538.00	27,042,662.00	63.9
210202	Тэтгэмжийн даатгал	8,813,400.00	4,821,834.81	3,991,565.19	54.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,406,700.00	2,380,107.01	2,026,592.99	54.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,406,800.00	2,380,107.01	2,026,692.99	54.0
210205	Эрүүл мэндийн даатгал	17,626,900.00	9,520,428.07	8,106,471.93	54.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,000,500.00	90,623,070.00	377,430.00	99.6
210304	Байрны түрээс	91,000,500.00	90,623,070.00	377,430.00	99.6
2104	Хангамж, бараа материалын зардал	24,340,600.00	24,313,470.87	27,129.13	99.9
210401	Бичиг хэрэг	6,957,000.00	6,951,930.00	5,070.00	99.9
210402	Тээвэр, шатахуун	3,600,000.00	3,600,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,783,600.00	7,779,861.87	3,738.13	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,000,000.00	5,981,679.00	18,321.00	99.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	62,011,000.00	61,982,400.00	28,600.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	49,050,000.00	49,045,000.00	5,000.00	100.0
210604	Урсгал засвар	12,961,000.00	12,937,400.00	23,600.00	99.8
2107	Томилолт, зочны зардал	31,856,000.00	31,784,242.00	71,758.00	99.8
210701	Гадаад албан томилолт	22,040,600.00	21,989,242.00	51,358.00	99.8
210702	Дотоод албан томилолт	9,815,400.00	9,795,000.00	20,400.00	99.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	201,310,000.00	162,057,025.60	39,252,974.40	80.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	182,830,000.00	144,582,183.60	38,247,816.40	79.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,480,000.00	17,474,842.00	1,005,158.00	94.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,800,000.00	1,649,000.00	151,000.00	91.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,800,000.00	1,649,000.00	151,000.00	91.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000.00	966,500.00	533,500.00	64.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	966,500.00	533,500.00	64.4

Хөрөнгө оруулалт, худалдааны газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	966,500.00	533,500.00	64.4
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,405,329,300.00	909,839,972.46	495,489,327.54	64.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,405,329,300.00	909,839,972.46	495,489,327.54	64.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,405,329,300.00	909,839,972.46	495,489,327.54	64.7
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	30	16	14	53.3
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	22	10	12	45.5
620003	Үйлчлэх ажилтан	7	5	2	71.4

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 14,216.6 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүү байдлын тайлан дахь үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдлийн дүнг нийт 14,216.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	14,216.6			1	14,216.6	1	14,216.6				
Дүн	1	14,216.6			1	14,216.6	1	14,216.6				

Хөрөнгө оруулалт, худалдааны газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

3.2 Аудитаар илэрсэн нийт 8,356.4 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс, 939.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 7,417.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тус газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/09 дүгээр тушаалын дагуу Монгол Улсын хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомж, эрх зүйн орчин, байгууллагын хөрөнгө оруулалт, худалдааг дэмжих үйл ажиллагааг Олон Улсад сурталчлах олон нийтийн цахим платформын эрх авах зардалд нийт 10,676,000.00 /арван сая зургаан зуун далан зургаан мянга/ төгрөгийн санхүүжилтийг олгосноос, 939,458.96 /есөн зуун гучин есөн мянга дөрвөн зуун тавин найман төгрөг ерэн зургаан мөнгө/ төгрөг нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.	1	939.4	1	939.4	-	-	-	-
2	Ажил олгогчийн санаачлага, тушаал, шийдвэргүйгээр албан хаагчдад илүү цагийн нэмэгдэл хөлсийг тооцож олгосон байна.	1	-	-	-	1	-	-	-
3	Төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант онд ажиллагчидтай холбогдсон 473.0 мянган төгрөгийн авлага, 144.0 мянган төгрөгийн өглөг үүсгэж ажилласан байна.	1	617.0	-	-	-	-	1	617.0
5	Тус газрын "Ажил гүйцэтгэх" АГГ24/03 дугаар гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын тайлангүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, "Үйлчилгээ үзүүлэх" ҮҮГ24/10 дугаар гэрээг 2024.12.02-ны өдрөөс 2025.01.31-ний өдөр хүртэл буюу төсвийн жил дамжуулан гүйцэтгүүлэхээр байгуулж, санхүүжилтийг бүрэн олгосон байна.	1	6,800.0	-	-	-	-	1	6,800.0
Дүн		4	8,356.4	1	939.4	1	-	2	7,417.0

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Архивын өрөө нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан стандартад нийцээгүй, цахим архив үүсгээгүй, байгуулагдсан цагаас улсын төв архивт баримтаа шилжүүлээгүй, баримт бичиг устаж алга болох эрсдэлтэй байна.	1	-	-	-	1	-
Дүн		1	-	-	-	1	-